



2026 ОН I УЛИРЛЫН ТАЙЛАН

MSE:MLG
www.mlholding.mn



КОМПАНИЙН ТУХАЙ

Монложистикс Групп нь 2025 онд тээвэр зуучийн чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өдгөө 1 толгой компани, 7 охин компани, 210 гаруй ажилтан, дэлхийн 163 орны 800 гаруй харилцагч түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчтэй Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын тэргүүлэгч групп компани болсон байна. Монложистикс Групп нь Монгол Улсын эдийн засгийн чухал салбар болох тээвэр ложистикийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, иргэдийн өдөр тутмын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлохоос эхлэн уурхайн түүхий эдийг экспортлох, хөрш болон гуравдагч орнуудыг ачаа тээврээр холбох хүртэл импорт, экспорт, транзит, тракинг, карго зэрэг тээвэр ложистикийн бүх төрлийн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн үзүүлсээр байна.

Өнгөрсөн 20 жилийн турш бид харилцагч, ажилтнууд, түншүүдийнхээ итгэл дээр тулгуурлан, инновац, чанар, хариуцлагыг эрхэмлэж ажилласан бөгөөд энэ хугацаанд бизнесийн тогтвортой өсөлт, менежментийн шилдэг туршлага, дотоодын болон олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай групп компанийг бий болгожээ. Монложистикс Холдинг ХК нь группийн охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, тэдгээрт хүний нөөц, санхүү, мэдээллийн технологи, маркетинг, стратеги ба бизнес хөгжил, ложистик гэсэн 6 чиглэлд менежментийн үйлчилгээ үзүүлдэг толгой компани юм.



ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

І УЛИРЛЫН ТАЙЛАН 2026

ЭРХЭМ ЗОРИЛГО

ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

АЛСЫН ХАРАА

Бид 2030 онд орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж, улмаар Монгол Улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгоно.



ҮНЭТ ЗҮЙЛС



Өндөр чадвартай, мэргэжлийн хамт олон

Ажилтан бүр өөрийгөө олж нээн, авьяас чадвараа суралцах их хүсэл эрмэлзлээр хөгжүүлэн, оюун ухаан, хүч хөдөлмөрөө харамгүй зориулснаар өөртөө болон байгууллагад амжилт бүтээл дагуулж, бусдадаа үлгэрлэн манлайлах замаар дараагийн залгамж манлайлагч нарыг тасралтгүй төрүүлдэг байна.



Инновацлаг багийн сэтгэлгээ

Манай хамт олон инновац, бүтээлч сэтгэлгээгээрээ багийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан төгөлдөршүүлэхийн төлөө цаг үетэй хөл нийлүүлж, техник технологийн хөгжлийг хурдтай нэвтрүүлж, байнга шинийг санаачлагч багуудаас бүрдэнэ.



Хариуцлага, сахилга бат

Манай байгууллагын ажилтан бүр өөрийн хариуцсан ажлыг хийхдээ хувийн өндөр сахилга баттай байж, ажилдаа өөриймсөг сэтгэлээр хандаж, Монгол Улсын хууль тогтоомж, Группийн дотоод үйл ажиллагааны стандартыг ёс зүйтэй мөрдөж, ямар ч ажлыг туйлын хариуцлагатайгаар, чанар стандартын дагуу гүйцэтгэдэг байна.



Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Манай ажилтан бүр тасралтгүй суралцан, мэдлэг оюунаа тэлж, мэргэжлийн болон ерөнхий ур чадвараар цаг үетэйгээ үргэлж нийцэж, дэлхийн өнцөг булан бүрийн аль ч компанид тэнцэн ажиллах чадамж бүхий зорилго нэгт баг хамт олны нэг хэсэг байна.



Шударга, ил тод байдал

Манай бүх үйл ажиллагаа том жижиг, их багаас үл хамааран үнэнч шударга байх зарчим дээр суурилан бүхий л оролцогч талуудад шаардлагатай мэдээллийг нээлттэй ойлгомжтой, үнэн зөвөөр цаг ямагт хүргэж байх болно.

ГРУППИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ

Монголын Тээвэр зуучийн
нэгдсэн холбоонд албан
ёсны гишүүнээр элсэв.

2006 ОН

Монгол Улсын Гаалийн
ерөнхий газраас Гаалийн
зуучлагчийн тусгай
зөвшөөрлийг авав.

2010 ОН

Олон улсын тээвэр
зуучийн нэгдсэн
холбоонд албан ёсны
гишүүнээр элсэв.

2014 ОН

Rebranding
“Upgrade 10” төслийг
амжилттай эхлүүлэв.

2016 ОН

2005 ОН

Монложистикс Ворлдвайд ХХК
анхны ууган компани
байгуулагдав.

2009 ОН

Төмөр замын аюулгүй
ажиллагааны тусгай
зөвшөөрлийг хүлээн авав.

2011 ОН

Монголын гаалийн
зуучлагчдын
нэгдсэн холбооны
гишүүнээр элсэв.

2015 ОН

ISO 9001:2008 Олон улсын
чанарын удирдлагын
тогтолцоог нэвтрүүлэв.





Оюу толгой компанийн албан ёсны тээврийн компаниар шалгарав.



Монложистикс Холдинг ХХК
Толгой компани байгуулагдав.



Түүхий эдийн экспортын тээврийг эхлүүлж, Кaus Аустралис ХХК-ийг байгуулав.



Группт Төв Азийн Зам ХХК нэмэгдэв.

CORE системийн шинэчлэл хийгдэв.

2018 ОН

2020 ОН

2022 ОН

2024 ОН



2017 ОН

2019 ОН

2021 ОН

2023 ОН

2025 ОН

Бүх тээврийг даатгалд хамруулах үйлчилгээг нэвтрүүлэв.

Монложистикс Транзит ХХК байгуулагдав.


Портфолио өргөжилт хийж, 3 охин компаниа байгуулав.

Монложистикс Холдинг ХХК Олон нийтэд нээлттэй компани болов.

Монложистикс групп үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ой тохиолоо.



ГРУППИЙН БҮТЭЦ



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Менторшип хөтөлбөр хэрэгжиж эхэллээ.

Монложистикс Группийн “Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл” үнэт зүйлийн хүрээнд, ажилтнуудыг хөгжүүлэх, ирээдүйн гүйцэтгэх удирдлагуудыг дотоод нөөцөөс бэлтгэх зорилготой “Менторшип хөтөлбөр-2026” эхэллээ. 2026 оны турш үргэлжлэх уг хөтөлбөрийг Монложистикс Группийн үүсгэн байгуулагч нар болох Л. Ганзоригт, Б. Тэлэнгэд нар болон ТУЗ-ийн гишүүн С. Энх-Амгалан нар удирдан хэрэгжүүлэх юм.



Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллалаа.

Хувьцаа эзэмшигчид, олон нийт, нийт оролцогч талууддаа мэдээллийг ил тод, нээлттэй хүргэх зарчмын дагуу Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал Г. Хишигбат CNBC мэдээллийн сувгийн ярилцлагад оролцож, компанийн бизнесийн үйл ажиллагаа болон салбарт, бүр цаашлаад Монгол Улсад болон олон улсад болж буй үйл явдал, нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгсөн. Мөн хувьцаа эзэмшигчдэд зориулан Earning Call-д оролцож, 2025 оны санхүү, үйл ажиллагааны тайлан, голлох үзүүлэлт, өсөлт болон стратегийн шинэчлэлүүдийг танилцуулсан.



Монголын спортын наадмыг ивээн тэтгэлээ.

“UNC Монголын спортын наадам 2026” арга хэмжээ зохион байгуулагдаж, нийт 10 спорт холбоо, 11 спортын төрөл, 1886 шилдэг тамирчид 8 өдрийн турш, 120 багц медалын төлөө өрсөлдөж Монгол улсын 2026 оны шилдгүүд тодруулсан юм. Монложистикс групп нь уг наадмын зохион байгуулалтыг шинэ тутам сайжруулж, мэргэжлийн, хүртээмжтэй болгоход “Хамтын үнэ цэн”-ийг хамтдаа цогцлоож, албан ёсны хамтран ажиллагчаар оролцлоо.

ОНЦЛОХ ТЭЭВЭР



Зуурмагийн үйлдвэрийн 10 машин тээвэр

Max Machinery Industry компанийн Zoomlion 120 болон 180 загварын бетон зуурмагийн үйлдвэрийн нийт 10 машин тээврийг 2026 оны нэгдүгээр улиралд амжилттай гүйцэтгэв. Төслийн мэргэжлийн зохион байгуулалт, овор хэтрүү ачааны стандарт, бэхэлгээ, аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллаа.



Хүнд даацын тоног төхөөрөмжүүд

Нэгдүгээр улиралд мөн Эрдэнэт үйлдвэрийн тус бүр нь 77.9 тонн жинтэй 2 ширхэг хүнд тоног төхөөрөмжийг Герман улсаас Эрдэнэт хот хүртэлх олон улсын тээврийг амжилттай зохион байгуулж гүйцэтгэлээ.



Нисдэг тэрэгний тээвэрлэлт

Улаанбаатар – Эрээн чиглэлд нисдэг тэрэгний экспортын тээвэр буюу үнэ цэнтэй, эмзэг ангиллын ачааг шаардагдах аюулгүй ажиллагаа, нарийн зохион байгуулалтыг хангаж, хил дамнасан тээврийн урсгалыг амжилттай зохион байгуулав.




Үйл ажиллагааны тайлан

- › Тээврийн салбарын нийт орлого
- › Монложистикс Группийн орлого
- › Тээврийн салбарын ачааны нийт хэмжээ
- › Монложистикс Группийн ачааны хэмжээ




МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ОРЛОГО

/ ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР /




2026 оны 1-р улирлын байдлаар Монложистикс Группийн орлого 65 тэрбум төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс +2.2% өссөн байна.

ТЭЭВРИЙН САЛБАРЫН НИЙТ АЧААНЫ ХЭМЖЭЭ / СЯ ТОННООР /





2026 оны 1-р улирлын байдлаар Монгол Улсын нийт ачаа тээврийн эргэлтийн хэмжээ 43.5 сая.тн хэмжээнд хүрч өмнөх мөн үетэй харьцуулахад 51% өссөн байна.

МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН АЧААНЫ ХЭМЖЭЭ / МЯНГАН ТОННООР /





Монложистикс группийн ачаа эргэлт 202 мян.тн хүрч өмнөх оны мөн үеэс 14% өссөн үзүүлэлттэй байна.



ЭКСПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ




ИМПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ



ТРАНЗИТ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ



ОЛОН УЛС ДАХ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ





САНХҮҮГИЙН ТАЙЛАН

НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Орлогын тайлангын үзүүлэлт (сая ₮)	2025 Q1	2026 Q1
Борлуулалтын орлого	63,954	64,779
Борлуулалтын өртөг	(58,266)	(59,030)
Нийт ашиг	5,688	5,749
Борлуулалт, Удирдлагын зардал	(2,378)	(2,304)
Бусад орлого (зардал)	1,331	(144)
Үйл ажиллагааны цэвэр ашиг	4,640	3,301
Санхүүгийн орлого (зардал)	(318)	(793)
Татварын өмнөх цэвэр ашиг (EBT)	4,323	2,508
ОАТ-н зардал	(169)	(107)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	4,154	2,401
Цэвэр ашиг	4,154	2,401
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	3,117	1,957
Хяналтын эрхгүй хувь оролцоо	1,037	444
Бүх дэлгэрэнгүй орлого		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	2,034	-
Бусад олз (гарз)	205	(46)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	6,393	2,335
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	5,356	1,911
Хяналтын эрхгүй хувь оролцоо	1,037	437
Нэгж хувьцаанд ноогдох ашиг суурь ашиг (алдагдал)	7.87	5.01

НЭГТГЭСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлангын үзүүлэлт (сая ₮)	2025 Q1	2026 Q1
Мөнгөн хөрөнгө	10,832	4,539
Дансны авлага	36,510	50,737
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1,146	2,568
Бараа материал	17,582	6,022
Урьдчилж төлсөн төлбөр	21,381	12,122
Бусад эргэлтийн хөрөнгө	1,408	1,659
Эргэлтийн хөрөнгө	88,859	77,647
Үндсэн хөрөнгө	5,245	14,207
Ашиглах эрх бүхий хөрөнгө	480	306
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,084	773
Гудвилл	3,463	3,518
Эргэлтийн бус хөрөнгө	10,272	18,804
Нийт хөрөнгө	99,131	96,451
Дансны өглөг	19,852	14,568
Урьдчилж орсон орлого	8,727	4,913
Богино хугацаат зээл	11,304	9,659
Бусад өглөг	2,504	334
Богино хугацаат өр төлбөр	42,386	29,474
Урт хугацаат өр төлбөр	6,729	9,815
Нийт өр төлбөр	49,115	39,289
Эздийн өмч	43,449	48,605
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	6,567	8,557
Нийт Эздийн өмч	50,016	57,161
Нийт өр төлбөр ба Эздийн өмч	99,131	96,451

*Аудитлагдаагүй тайлан



ХАЯГ

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Нью хоризонс оффис, 11 давхар, 1101 тоот

ХОЛБОО БАРИХ

+976 7701-5454
info@monlogistics.mn
www.mlholding.mn